

**МОНГОЛЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬД УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛ  
ОЛГОЖ ИРСЭН ТҮҮХЭЭС**

**Д.ОДМАА**

Доктор, ШУТИС, БУХС,

*Нийгмийн ухааны салбарын ахлах багш*

**Түлхүүр үг:** Улс төр, ШУКО, улс төр судлал, сургалт, агуулга, хөтөлбөр

**Хураангуй:** Өнөөгийн нийгэмд дээд боловсролтой мэргэжилтэн нь эзэмшсэн мэргэжлээсээ үл хамааран оюуны өндөр чадавх, бүтээлч сэтгэлгээ, хариуцлагатай байдал, багаар ажиллах, шийдвэр гаргах зэрэг чадваруудыг эзэмшихийн зэрэгцээ улс төр, эдийн засаг, урлаг соёлын зохих түвшний мэдлэгтэй байх шаардлага тавигдах болсон. Тиймээс улс төрийн боловсролыг оюутнуудад эзэмшүүлснээр тэдний улс төрийн ухамсар, соёлыг төлөвшүүлэх, улс төрд хандах хандлагыг өөрчлөх чухал ач холбогдолтой юм. Ер нь иргэдийн улс төрийн боловсрол, соёл, ухамсар, дээшлэхийн хирээр тэдний улс төрд оролцох оролцоо дээшилж, өөрсдийн үзэл бодол, ашиг сонирхолыг аливаа шийдвэрт тусгуулах, төр засгийн үйл ажиллагааг үнэлэх, хяналт тавих, цаашлаад улс төрийн амьдралыг эрүүлжүүлэх, тогтворжуулахад чухал хувь нэмэр оруулдаг. Тиймээс энэхүү өгүүлэлд манай улсын их, дээд сургуульд улс төрийн боловсролыг хэрхэн олгож ирсэн, хичээлийн нэр, сургалтын хөтөлбөр түүний агуулга нь хэрхэн өөрчлөгдөж байсан зэргийг архивын эх сурвалжид үндэслэн бичсэн болно.

\*\*\*\*\*

Манай улсын хувьд улс төрийн мэдлэг боловсрол олгож ирсэн эртний түүхтэй бөгөөд тухайлбал, Их засаг хуулинд монгол хүнд төр засгаа дээдлэх үзлийг төлөвшүүлэхэд ач холбогдол өгч байсан байна. Чингис хааныг дээдлэн хүндэтгэх нь иргэн бүрийн үүрэг байх ба ингэснээр улсынхаа бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрч төрөө дээдэлж байгаагийн нэг илэрхийлэл болдог байснаас иргэдэд хааныг дээдлэх үзлээр дамжуулан төрийг дээдлэх үзлийг төлөвшүүлдэг байв. Энэ тухай Ж.Вернадский “Төрийн дээд эрх хаан хүнд төвлөрч, хан шол нь төрийн дээд эрхийн баталгаа болно” гэж тэмдэглэсэн нь бий[1]. Монголын түүхийн тулгуур зохиолууд болон дэлхийн янз бүрийн улс орны эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд дурдагдан үлдсэн “Их засаг”-ийн заалтуудын агуулгыг нэгтгэн дүгнэж үзвээс уг хууль нь Монголын нэгдсэн төрийн хэлбэр, дэглэм, хааны хэмжээгүй эрх мэдэл, хаанд өргөмжлөгдөх ёс, төрийн байгууллагууд, тэдгээрийн зохион байгуулалт, эрх үүрэг, ажиллах журам, төрийн түшмэдийн зэрэг, эрх ямба, үүрэг хариуцлага, төрийн удирдах, удирдуулах ёсон, гадаад дотоод бодлого, ял ногдуулах, эдлүүлэх зарчим, журмыг тодорхойлон тогтоосон улсын гол хууль байжээ хэмээн хэлж болох ажгуу [2]. Ингэж хуулиар дамжуулан төрийг дээдлэх үзэл, хааныг хүндэтгэх үзэл, хууль сахиж ёс зэрэгт сургадаг байжээ.

Монгол уламжлалт сургалт, боловсролын талаар Б.Ренчин, Ш.Гаадамба, Б.Жадамба, Д.Баттогтох, Х.Дарамбазар, О.Дагвадорж, Ж.Лувсандорж, Д.Наран, Ш.Шагдар, Г.Эрдэнэ-Очир тэргүүтэй мэргэд чамгүй их судалгаа явуулж, арвин баримт материал хуримтлуулсан байдаг. Тухайлбал, Б.Ренчин манай боловсролын уламжлалт тогтолцоог авч үзэхдээ шарын шашны сургуультай, төрийн сургуультай, монгол бичгийн сургуультай гэсэн 3 зүйлийн сургуультай байна гэжээ. Мөн судлаач Д.Баттогтох “Боловсрол мэдлэг, мэргэжил олгох зорилготой 3 хэв шинжийн сургууль байжээ гэж тэмдэглэсэн байна. Энэ нь үндэсний хэл бичгээр унших бичих, тоо бодох, зурах, урлах, бие махбодыг тамиржуулах, хүмүүжүүлэх зорилготой иргэний суурь боловсрол олгох гэрийн сургууль, төвд хэл бичиг зааж шашны суурь боловсрол эзэмшүүлэх буюу сүм хийдэд хурлын лам нарыг бэлтгэх шашны сургууль, хууль цааз, төр захиргааны боловсрол олгох буюу төрийн түшээ, тамгын ажилтанг бэлтгэх төрийн сургууль” ажээ. Судлаач Д.Наран хятад түүхэн сурвалжийг судлан Монголын төрт ёсны боловсролын талаар чухал баримтыг илрүүлсэн байна. Энэ нь Өгөдэй хаан Алтан улсын нийслэл асан Яньжин хотноо урьд нь Алтан улсын Нууц бичгийн яам байсан газар Их Монгол улсын хаан хөвгүүд, хишигтэн ноёд, дээдэс язгууртны хөвгүүдийг сургах “Улсын хөвүүдийн сургууль”-ийг 1233 онд байгуулан анхны монгол 18 сурагчийг тийш илгээн суралцуулж байв. Энэ бол албан ёсны боловсрол монголд эрт цагаас үүсэн хөгжсөнийг нотолж байна.[3] Монголчууд XIII-XIV зууны үед хүчирхэгжин мандсны нэг гол шалтгаан нь боловсролын асуудлыг чухалчлан үзэж, эрдэм мэдлэгтэй, авъяас чадвартай, мэргэн цэцэн хүмүүсээр төрийн алба хашуулах чиг шугамыг баримтлан, нийгмийн дээд давхаргынхны дотроос шилдэг хөвгүүд залуучуудыг сонгон авч, тэдэнд тухайлсан боловсрол эзэмшүүлэх, уг ажлыг эрхлэх сургуулийг байгуулан ажиллаж байсан явдал юм. Тиймээс манай улсын дээд боловсролын үүслийг 700 гаруй жилийн тэртээх түүхэн үйл явцтай холбон авч үздэг.

Харин орчин цагийн боловсролын тухайд 1924 онд Монгол ардын нам шинэ үеийн боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор намын түр сургуулийг байгуулж улмаар намын төв сургууль болгон өргөжүүлсэн явдал нь манай улсын дээд боловсролын түүхэнд нэгэн шинэ хуудас нэмсэн билээ. Монгол ардын нам шинэ цагийн мэдлэг боловсрол бүхий боловсон хүчин бэлтгэх ажилд идэвхийлэн орж, 1924 оны 4 сарын 5-нд Халхын 4 аймаг, шавиас зарлан дуудаж ирүүлсэн 18-30 насны 60 залуучуудаас бүрдсэн "Нам, улсын Түр сургууль"-ийг үүсгэн байгуулжээ. 1925 оны 1 сарын 10-ны өдөр НТХ-ны Тэргүүлэгчдийн II хурлын тогтоолын 3 дугаар зүйлд "Намын сургуулийг тусгайлан байгуулж, харьяат гишүүдийг сургах нь чухал" хэмээн үзэж, Намын Төв Сургуулийг байгуулан дүрэм, сургалтын төлөвлөгөө, багшлах боловсон хүчний тухай хэлэлцэж баталсан байна. Тухайн үед монгол хэл, бичиг, тоо бодлого, түмэн бодис, дэлхийн байдал зэрэг нийт 850 цагийн хичээл орж байв. Эдгээрхичээлүүдийн агуулгыг сонирхож үзэхэд нам, намын түүх, намын үзэл суртал гэх зэргээр хэт түйлширдаггүй байсан батухайлбал: "Дэлхийн байдал" хичээлийн агуулгад улс төрийн талаар цухас дурдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Энэ хичээлийн агуулгыг сийрүүлвэл *"Ази, Европ ба Африк тивийн газар нутаг, улс, гол мөрөн, ургамал амьтны байдал болон ямар овог аймгийн улс, хаана сууж хэрхэн амьдарч суугаа, эдгээр 3 тивд ямар улс төр, ямар төр засагтай буй бас эзэрхэг улсуудын колонгуудыг тус тус заасан болой"* [4] гэжээ.

Харин манай улсын хувьд улс төрийн мэдлэг, боловсролыг албан ёсны хичээл сургалтаар олгож ирсэн түүхэн үе нь 1925 оноос эхэлсэн байдаг. Намын төв сургуульд зааж байсан улс төр хичээлийн хөтөлбөр түүний агуулгыг авч үзвэл тэр үеийн сургалтын төлөвлөгөөнд тусгаснаар бүгд 360 цагийн сургалтаар улс төрийн мэдлэг олгодог байжээ.

Намын төв сургуулийн сургалтын төлөвлөгөө /1925 он/

Улс төрийн хичээл

1. Монголын үндэсний хувьсгалын явдал ба МАХН-ын түүх-50 цаг
2. Засаг, засаглалын тухай-50 цаг
3. Монгол ба зэргэдээ улсын аж байдал-50 цаг
4. Хүн төрөлхтөн хэрхэн боловсорч ирсэн түүх-50 цаг
5. Хөрөнгөтний ёс-60 цаг
6. Бүх дэлхийн хувьсгалын түүх-100 цаг байв. [5]

Эндээс үзвэл уг хичээлийн агуулгад улс төр, эдийн засаг, түүхийн судлагдахууныг хамтатган судалдаг байжээ. Сургуулийн сургалт хүмүүжлийн ажлыг үзэл сурталжуулах явдал 1925 онд хуралдсан МАХН-ын IV их хурлаас баталсан намын II хөтөлбөрт "Олон сургуулийн заах зүйлүүдэд улс төрийн хэрэгт суралцах зүйлийг оролцуулах" гэж зааснаар эхэлсэн хэдий ч тухайн үеийн улс төрийн хичээлийн агуулга нь хэт үзэл сурталжаагүй, Монголын болон дэлхийн улсуудын түүх, хувьсгалт тэмцлийн түүхийн талаар түлхүү заадаг байсныг дээрх хөтөлбөрөөс харж болно. Үүнээс үзвэл тухайн үеийн намын төв сургуульд зааж байсан "Улс төр" хичээл нь нэршлийн хувьд л улс төр хэмээн нэрлэгдэж байсан боловч агуулгын хувьд өөр байсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Гэсэн хэдий ч энэхүү сургууль нь манай оронд орчин цагийн улс төрийн шинжлэх ухааны үндэс суурь тавигдаж цааш хөгжиж эхлэх хөрс суурь нь болсон гэдгийг үгүйсгэж болохгүй.

Түүнчлэн 1932 онд тус сургуулийн захирал Цэвэгжав тэргүүтэй төлөөлөгчид Зөвлөлтийн намын сургуульд ажлын айлчлал хийж, холбоо тогтоон тэндээс сургалтын материал, хэрэгсэл, хичээлийн программ, гарын авлага, сурах бичиг хүлээн авч сургалтандаа хэрэглэх болсноор улс төрийн үзэл сурталыг номлол болгох явдал нэмэгдсэн гэж үзэж болох юм. 1934 оны Намын ба улсын төв сургуулийн хичээлийн программ, төлөвлөгөөнүүдэд тусгаснаар Монгол бичиг, Дэлхийн байдал, Химийн ухаан, Цэргийн боловсрол, Тоо бодлогын ухаан, Байгалийн шинжлэл, Улс төр зэрэг 20 хичээл орж байжээ. Уг эх сурвалжид тэмдэглэсэнээр улс төр хичээлийн агуулга нь *"Хүн төрөлхтний түүхээс эхлэн, хөрөнгө нийтийн байдал ба намын дүрмийг зааж буй болно"* [6] гэжээ. Харин сургалтын хөтөлбөрийн тухайд:

## Хүснэгт 1

## Нам ба улсын төв сургуулийн нэгдүгээр ангид заах улс төрийн хичээлийн программ [7]

№	Бүлэг сэдвийн нэр	Цаг
1	Улсын байгуулалтын тухай	70
2	МАХН-ын байгуулалтын тухай	60
3	Монгол улсын түүх	108
4	Хүн төрөлхтөний нийгмийн хөгжлийн түүх	60
5	БНМАУ-ын ардын засгийн тухай	100
6	МАХН-ын түүх	30
7	Ленинизм /Лениний суртлын үндсүүд/	50
Бүгд		498

Уг хөтөлбөрт тусгаснаар Монголын түүх, МАХН-ын түүх, Улсын байгуулалт, Намын зохион байгуулалт, Ленинизмын үндэс, Дэлхий дахины түүх зэрэг хичээлийг “Улс төр” гэдэг нэрийн дор багтааж нэг хичээл болгон зааж байсан байна. Тухайлбал, Улсын байгуулалтын тухай бүлэг нь:

- Манай улс болбаас ардын хувьсгалт засагтай улс болох нь
- Эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцсэн улс болох учир манай улс нь шинэ маягийн Бүгд

Найрамдах Улс болох тухай

- Хөрөнгөтний Бүгд Найрамдах Улсуудаас ялгавартай нь
- Ардын хувьсгалт засгийн ач тус ба ерөнхий зорилгууд
- Үндсэн хуудийн тухай
- Улсын анхдугаар Их Хурал, УИХ-ын дүрэм
- Улсын Бага Хурал ба Сайд Нарын Зөвлөл тэдгээрийн дүрмүүд
- Яамд, улсын байгууллагуудын тухай
- БНМАУ-ын засаг захиргааны хуваарь
- Сонгуулийн журам
- Тус улсын доторх улс төрийн ба гэгээрэл боловсролын ажлыг явуулах байгууллагуудын үүрэг
- Улс орныг батлан хамгаалах хүчин ардын хувьсгалт цэрэг түүнийг дайчлан татах журам,

цэргийн албыг хаах тухай хууль [8] зэрэг агуулгыг багтаасан байжээ.

Улмаар 1938 оноос улс төрийн хичээлийн агуулгад багтаж байсан бүлэг сэдвүүдийг бие даасан хичээл болгон өөрчилж, улс төрийн гэх нэршлийг хэрэглэхээ больжээ. Тухайлбал, Улсын байгуулалтын тухай хичээлийг 100 цаг, Намын зохион байгуулалтын хичээлийг 70 цаг, МАХН-ын түүх хичээлийг 130 цагаар тус тус зааж байв. Үүнээс хойш Улсын байгуулалт, МАХН-ын түүх, Марксизм-Ленинизмын онол, Шинжлэх ухаан коммунизмын онол /цаашид ШУКО гэх/ зэрэг хичээлийн нэрийн доор улс төрийн ойлголтыг тодорхой хэмжээгээр заадаг байжээ. Гэхдээ энэхүү хичээл сургалт нь улс төрийн шинжлэх ухааны гэхээсээ илүүтэй марксизм-ленинизмын онолын асуудлыг бүхэлд нь тусгасан шинжтэй байлаа.

Социализмын үеийн боловсрол нь бүхэлдээ Марксист Ленинист философид үндэслэсэн бүх талын өв тэгш хүмүүжилтэй, социалист бие хүн төлөвшүүлэхэд чиглэсэн байлаа. Залуу үеийг Марксист Ленинист үзэл, эх оронч дайчин, энх тайванч, интернационалч уламжлалаар хүмүүжүүлэх явдал Монголын социалист байгуулалтын үеийн боловсролын амин чухал зорилт байв. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд академик боловсрол олгож, түүний хажуугаар улс төрийн үзэл суртал, хүмүүжлийн ажлыг өргөнөөр зохион байгуулж байлаа. Үүний тод жишээ нь 1922 онд Намын Төв Хороонд Суртлыг дэлгэрүүлэх хэлтэс байгуулж өөрийн гишүүд, олон түмний дотор улс төрийн ухуулга суртлыг өргөн явуулах ажлыг өрнүүлж эхэлсэн явдал юм. Олон зуун жил ноёрхсон шашны үзэл суртал, сүсэг бишрэл, хүн амын соёлын хоцрогдол, тархай бутархай байдал, зам харилцаа хөгжөөгүй зэрэг нь намын үзэл суртлын ажилд саад тотгор болж байсан учир олон түмнийг бичиг үсэгт сургах ажилд ихээхэн анхаарсан байдаг. Тиймээс 1924 онд хуралдсан намын III их хурлаас “Насанд хүрсэн аливаа хүмүүсийг бичгийн эрдэмд боловсруулахыг хичээвээс улс төрийн дэвших замд их тустай” [9] гэсэн зорилт тавьж байсан. Уг зорилтыг биелүүлэхийн тулд танхимын сургалтаас гадна бүлгэм, дугуйлан, гэрийн сургалт, түр сургууль зэрэг хэлбэрийг ашиглаж намын нишүүдийг албадан сургах арга хүртэл хэрэглэж байсан. Энэ бүхэн МАХН-аас өөрийн гишүүдийг төдийгүй ард түмний улс төрийн боловсролыг системтэй дээшлүүлэх зохион байгуулалтын ажлын анхны хэлбэр байсан юм. 1927-1928 онуудад залуучуудын, эмэгтэйчүүдийн, үйлдвэрчний эвлэл зэрэг олон нийтийн байгууллагуудын улс төрийн ажилд зохион байгуулалттай оролцох хэлбэрүүд бий болж МАХН-ын Төв Хороо, Эвлэлийн Төв Хороо хамтарч

Маркс, Лениний улс төр, эдийн засгийн үндэс судлах бүлгэмүүд байгуулж улмаар 1930 он гэхэд намын хэмжээнд улс төрийн 15 бүлгэм суртал нэвтрүүлэгчдийн хоёр долоо хоногийн семинараар бэлтгэдэг болсон байна. Ийнхүү 1940 он гэхэд МАХН-ын улс төрийн боловсролын системийн баттай үндэс суурь бүрэлдсэн гэж судлаачид үзсэн байдаг [10]. Улс төр, олон нийт, сайн дурын байгууллагаар дамжуулан зохион байгуулж байсан ийм үзэл суртлын ажлууд нь өсвөр үеийг сурган хүмүүжүүлэхэд маш том байр суурь эзэлж байв.

1930-1940 оны үед монголын сурган хүмүүжүүлэх ухаан, дидактикт хийгдсэн нэг том өөрчлөлт нь бүх нийтийг, адил тэгшээр, улсын хэмжээгээр нэгдсэн хөтөлбөрөөр сургах анги-хичээлийн систем биеллээ олж, боловсролын агуулгыг оновчтой болгох анхны оролдлого хийгдэж, дээд боловсролын сургалтын арга зүйг боловсруулж эхэлсэн явдал юм [11]. Тиймээс манай оронд нэг талаас их дээд сургуульд элсэх бэлтгэл хангахуйц бүрэн дунд сургуультай болсон, нөгөө талаас улс орны улс төр, нийгэм эдийн засаг, соёлын салбарт төрөл бүрийн мэргэжлийн дээд боловсролтой мэргэжилтэн шаардагдаж эхэлснийг харгалзан, үндэсний орчин үеийн их дээд сургуулийг байгуулах нь нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлага байлаа. Ийнхүү БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1940 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн тогтоолоор “Улаанбаатар хотод улсын их сургуулийг байгуулах тухай” шийдвэр гарч, их сургуулийг байгуулах бэлтгэл ажлыг хийж, улмаар 1942 оны 10 дугаар сарын 5-нд зоотехник, сурган хүмүүжүүлэх, хүн эмнэлгийн 3 ангитайгаар улсын их сургуулийг байгуулсан түүхтэй [12]. МУИС-ийн хөгжлийн явцад гарсан нэгэн шинэ зүйл бол дээд сургууль төгсөгчдөд нийгмийн ухааны боловсрол олгох, мөн нийгэм хүмүүнлэгийн ухааны дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх болсон явдал юм. Энэ тухай эх сурвалжид: “*Марксист шинжлэх ухаан, намын түүх, улс төр, эдийн засаг, философийг сайнаар эзэмшиж чаддаг түүнчлэн эдгээр ухааныг зөвхөн мэдээд зогсохгүй, эрдэм шинжилгээний ажлыг хийдэг ба мөнхүү ухааныг бусад ба дунд сургуулиудад зааж чадах чадвар бэлтгэл бүхий шинэ хүчнийг гаргахын тулд одоогоос эхлэн бэлтгэлийг хийж ирэх хичээлийн жилээс нийгмийн шинжлэх ухааны факультетийг нээсүгэй*” [13] хэмээн дурджээ. Энэ үндсэн дээр зохих бэлтгэл ажлыг хангаж, 1947-1948 оны хичээлийн жилд Нийгмийн Шинжлэх Ухааны Факультетийг нээсэн байна.

БНМАУ-ын дээд сургуулийн дүрэмд /БНМАУ-ын СНЗ-ийн 1962 оны 535 дугаар тогтоолоор батлагдсан/ зааснаар дээд сургуулийн профессор багш нарын үүрэг бол “Оюутныг үзэл суртал, улс төрийн өндөр ухаамсартай болгон хүмүүжүүлэх, улс төрийн мэдлэг, үзэл суртлынхаа хэмжээг ямагт дээшлүүлэх, мэргэжлийн болон онолын мэдлэг, дадлага туршлагаа байнга нэмэгдүүлэх” гэжээ. Мөн их дээд сургуулийн нийгэм, хүмүүнлэгийн ухааны хичээлийн сургалтанд онцгой ач холбогдол өгч философи, МАХН-ын түүх, ШУКО-ын хичээлээр улсын шалгалт авах болсон нь дээд боловсролын сургалт үзэл сурталжсаны тод жишээ байв.

1964 онд болсон нийгмийн ухааны багш нарын зөвлөгөөн бүх шатны сургуулийн нийгмийн ухааны хичээлийн үзэл суртлын түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн бөгөөд уг хичээлүүд нь 1990 оныг хүртэл дээд, тусгай мэргэжлийн дунд сургуулийн сургалтын төлөвлөгөөн дэх бүх хичээлийн цагийн 30 орчим хувийг эзэлж байлаа [14]. Эдгээр нийгмийн ухааны хичээлүүдийг ЗХУКН-ын түүх, МАХН-ын түүх, Марксист, Ленинист философи, Улс төрийн эдийн засгийн ухаан, Шинжлэх ухааны коммунизмын үндэс гэсэн дарааллаар үзнэ хэмээн тогтоол гаргаж, сургалтыг улс төржүүлэх ажлыг улам хүчтэй болгосон. 1965 оныг хүртэл Марксизм-Ленинизмын онол хичээлийн агуулгад философи, түүх, шинжлэх ухаан коммунизмын хичээл багтаж байсан гэж үзэж болно. Улмаар шинжлэх ухааны коммунизмын онолын хичээлийг 1965 оноос их дээд сургуулийн төгсөх ангид 70 цагаар үзэж эхэлжээ [15]. Ингэхдээ бүх сургуулийн мэргэжлийн биш ангиудад орж байгаа нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөр, цагийн хэмжээ адил байсан байна.

## Хүснэгт 2

## Шинжлэх ухаан коммунизмын үндсүүд хичээлийн программ

Бүлгийн нэр	Сэдвийн нэр	Цаг
Нэгдүгээр бүлэг: ШУКО бол Марксизм-Ленинизмын нэг бүрэлдэхүүн хэсэг мөн-10 цаг	ШУКО-ын судлах зүйл	2
	Үл гүйцэлдэх социализм бол ШУКО-ын эх сурвалж мөн	2
	К.Маркс, Ф.Энгельс нар бол ШУКО-ыг үндэслэгчид мөн	3
	Шинжлэх ухаан коммунизмын хөгжил дэх Ленины үе	3
Хоёрдугаар бүлэг: Эрчн үеийн шинж чанар ба дэлхий дахины хувьсгалт үйл явц, социалист систем дэлхий дахины хөгжлийн шийдвэрлэх хүчин болж хувирсан нь-12 цаг	Аугаа их Октябрийн социалист хувьсгал бол капитализмаас коммунизмд шилжих шилжилтийн эхлэл мөн	2
	Социализм нэг орны хүрээнээс халин гарч дэлхийн социалист систем дэлхий дахины хөгжлийн шийдвэрлэх хүчин болж хувирсан нь	2
	Олон улсын ажилчин ангийн хувьсгалт хөдөлгөөн	2
Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний хөгжил		2
	Энх тайвнаар зэрэгцэн оршихуй ба бүх нийтийн энх тайвны төлөө тэмцэл	2
	Орчин үеийн шатан дахь коммунист хөдөлгөөн, коммунист ба ажилчны намуудын стратеги, тактикийн асуудлууд	2
Гуравдугаар бүлэг: Социалист нийгэм ба түүний хөгжлийн зүй тогтлууд-14 цаг	Капитализмаас социализмд шилжих шилжилтийн үе түүхэн ёсоор зайлшгүй болох нь	4
	Шилжилтийн үед пролетарийн диктатур зайлшгүй болох хийгээд түүний илрэх хэлбэрүүд	4
	Социалист нийгмийг байгуулах зүй тогтлууд, тэдгээрийн илрэх хэлбэр олон янз болох нь	4
	Социализм бол коммунизмын анхдугаар шат мөн	2
Дөрөвдүгээр бүлэг: Коммунист нийгмийн тогтнол ба хөгжлийн зүй тогтол-14 цаг	Социализмаас коммунизмд урган орох зүй тогтол	2
	Коммунизмын материал техникийн бааз бол коммунизмд шилжин ороход шийдвэрлэгч нөхцөл мөн	3
	Коммунист нийгмийн харилцаа бүрэлдэн тогтох нь	3
	Социализмаас коммунизмд шилжих үеийн нийгмийн улс төрийн байгууллага	2
	Хөдөлмөрдчийн коммунист хүмүүжил, коммунист нийгмийн гишүүн	2
	Дэлхийн социалист систем ба коммунизм	2

Семинарын хичээлийг нийт 20 цагаар орж байсан ба түүний агуулгад “Социалист хувьсгалын онол ба орчин үе-4 цаг, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний стратеги, тактикийн асуудлууд-4 цаг, янз бүрийн орнууд капитализмаас социализмд шилжин орох өвөрмөц онцлогууд, БНМАУ феодализмаас социализмд шилжсэн шилжилтийн онцлогууд-6 цаг, коммунист нийгмийн харилцаа бүрэлдэн тогтох нь-2 цаг, коммунист нийгмийн улс төрийн байгууллага-2 цаг, шинэ хүнийг хүмүүжүүлэх нь-2 цаг” тус тус багтаж байв.

1967-1968 оны хичээлийн жилээс улсын их сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг өргөтгөн өөрчилсний дагуу Марксизм-ленинизмын тэнхимээс ШУКО-ын тэнхим бие даан гарч, 1967 оны 10 сарын 1-нээс үйл ажиллагаагаа эхэлж, анхны багшаар Д.Содномгомбо, Д.Гарамжав, Д.Лувсанцэрэн нар ажиллаж байв. Мөн энэ онд ШУКО-ын сурах бичгийг орос хэлнээс орчуулах ажлыг эхлүүлж 1969 онд хэвлүүлсэн бөгөөд уг хичээлийн программыг шинээр боловсруулж, бусад дээд сургуулиудад мөн адил мөрдөж байв. 1973-1974 оны хичээлийн жилийн 2-р хагасаас ЗХУКН-ын түүх, ШУКО-ын хичээлийн программыг цаг үеийн шаардлага, ЗХУКН-ын XXV, МАХН-ын XVII их хурлын заалт онолын үндэслэлийн дагуу шинэчлэн боловсруулсан. Ингэхдээ МАХН-ын Төв хорооны шинжлэх ухааны шашингүйн суртал нэвтрүүлгийг хүчтэй болгох, хөрөнгөтөн орны амьдрал үнэн байдлыг

тайлбарлаж таниулах ажлыг сайжруулах тогтоол, маоизмын харгис мөн чанарыг шүүмжлэх зэрэг асуудлыг нэмж оруулсан байдаг. ШУКО-гийн толь бичгийг 1973 онд, сурах бичгийг 1974, 1975 онд хэвлүүлсний үндсэн дээр БНМАУ-ын их дээд сургуулиудад мөрдөх хичээлийн программ, семинарын хичээлийн төлөвлөгөө, сурах бичиг, унших ном зэргийг монгол хэлээр гаргасан. 1990 оноос өмнөх нийгмийн ухааны боловсролын агуулга нь социализмын ололтыг сурталчлан магтах, эдийн засгийн сургалт нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагт үйлчлэх, эрх зүйн сургалт нь нам төвт улс төрийн тогтолцоог бэхжүүлэхэд үйлчилж байсан бол [16], МАХН-ын 4 дэх удаагийн мөрийн хөтөлбөрт тусгаснаар их дээд, тусгай дунд мэргэжлийн сургуулиудаар улс төрийн боловсролтой мэргэжилтэн бэлтгэх асуудлыг чухалчилсан байдаг [17]. Тухайн үед социалист бусад оронтой нэгэн адил манай оронд марксизм бүхнийг хамарсан үзэл суртал нийгмийн оюун санааны амьдрал, тэр дотроо нийгмийн шинжлэх ухааны онол, арга зүйн үндэс, утга агуулга нь болж байлаа. Нийгмийн шинжлэх ухаанд ганцхан үнэн байсан нь марксизм юм. Түүний үндсэн гурван бүрдэл хэсгийн нэг болох коммунизм-социализмын онолыг марксизмын нийгэм улс төрийн номлол мөн гэж үзээд түүний агуулгын хүрээнд ажилчин ангийн тэмцэл, хувьсгал, төр, пролетарийн диктатур, нам, олон нийтийн байгууллага, үзэл суртал, улс төрийн ухамсар зэрэг улс төрийн үзэгдлийг марксизмын онолын дагуу авч үзэж байв. Энэ нь улс төрийн шинжлэх ухааныг социализмын онолоор ордуулж байсан хэрэг юм [18]. Эндээс үзвэл 1990 оноос өмнөх үеийн улс төрийн мэдлэг боловсрол олгож байсан хичээлүүдийн агуулга нь Орос улсын туршлагад тулгуурласан, сургалтын агуулга нь үзэл сурталжсан, хичээлийн хөтөлбөр нь гадны хөтөлбөрийг шууд хуулбарласан шинжтэй байв. Тухайн үед одоогийн улс төрийн шинжлэх ухааныг албан ёсоор хүлээн зөвшөөрдөггүй, бие даасан шинжлэх ухаан гэж үздэггүй байсны улмаас түүний онолын мэдлэгийн тогтолцоог "Улс төрийн мэдлэг", "Улс төрийн мэдлэгийн үндэс" гэх зэргээр нэрлэж, марксист онол, сургаалын үндсэн дээр боловсруулж нийтэд судлуулан түгээж байсан. Тухайн үеийн сургалт сурталчилгаанд хэрэглэж байсан нэлээд олон бүтээл байдаг ба тухайлбал, "Улс төрийн товч толь" 1964, "Улс төрийн боловсролын анхны мэдэгдэхүүн" 1972, "Нийгэм улс төрийн товч толь" 1973, "Улс төрийн мэдлэгийн үндэс" 1975, "Улс төрийн лавлах" 1986 гэсэн бүтээлүүдийг нэрлэж болно. 1943 оноос "Улс төрийн онолын өндөр судалгааны эмхэтгэл" хэвлэгдэх болж, багш Д.Төмөр-Очир, С.Жалан-Аажав нарын гүн ухааны ба ЗХУКН-ын түүхийн лекцийн олон олон цувралууд гарч, уншигчдын оюуны хэрэгцээг хангаж байв.

1990-ээд оны өмнөх улс төрийн сургалт, судалгаа нь онол-танин мэдэхүй, нийтлэгдсэн ном зохиол, мэдээллийн газрын хувьд хэдийгээр чухал ач холбогдолтой, үнэ цэнэтэй ч гэсэн өөрийн мөн чанар, шинжлэх ухааны статусаараа өрнө, дорнын орнуудад хөгжиж ирсэн улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгаатай яг адил биш, зарчмын чанартай олон зүйлээрээ өөр байсныг тэмдэглэх нь зүйтэй юм. Харин нийгмийн социалист систем нуран унаж, 1991 оны сүүлчээр ЗХУ задарсантай холбоотойгоор түүнийг судалж, зөвтгөн тайлбарлаж байсан социализм-коммунизмын онолын нэр хүнд, нөлөө буурч, учир утгаа алдаж эхэлсэн. Үүний нэг тод илрэл нь манай их дээд сургуулийн оюутнууд 1990-1991 оны хичээлийн жилээс шинжлэх ухааны коммунизмын онол, МАХН-ын түүхийн хичээлийг заахыг эсэргүүцэж, сургалтын төлөвлөгөөнөөс хасах тухай санал гаргаж байсан явдал юм [19]. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэж, Ардын Боловсролын Яамны сайдын 1990 оны 04 сарын 26-ны өдрийн 111 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад зааснаар их дээд сургуулийн суурь боловсрол олгох хичээлийн төрөлд "Улс төр судлал" орж [20], 1991-1992 оны хичээлийн жилд ШУКО-ын оронд улс төр судлалын хичээлийг заах нь зүйтэй гэж тухайн үеийн Ардын боловсролын яамны сайдын шийдвэр гарсан байна. Энэ шийдвэр гарсантай холбоотойгоор 1991 онд улс төр судлалын хичээлийг их дээд сургуульд заах талаар Нийгмийн ухааны зөвлөлөөс эрхлэн "Улс төр судлалын программ"-ыг товхимлын хэлбэрээр нийтлэн гаргасан байдаг. Уг программын агуулгад улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжил, судлах зүйл, судалгааны арга, сэтгэлгээний түүх, улс төрийн парадигм, төр, нам, үзэл суртал зэрэг онолын сэдвүүд тусгагдсан байв. Ингэж нийгмийн ухааны сургалтад тавигдаж байгаа шаардлага, оюутны санал хүсэлтэд тулгуурлан сургалтын төлөвлөгөө, хичээлийн программыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж, философи, монголын түүх, улс төр судлал хичээлүүдийн хөтөлбөр бүрэн шинэчлэгдэж мөрдөгдөж эхэлсэн ажээ. Хичээлийн программыг шинэчлэхдээ уг шинжлэх ухааны онолын түвшинг алдагдуулахгүйгээр нийгмийн практиктэй холбох, нэг үзэл баримтлалд автагдахгүйгээр нийт хүн төрөлхтний онолын сэтгэлгээний өв санг тусгах чиглэлийг баримтлалаа хэмээн эх сурвалжид дурдсан байдаг [21]. Үүнтэй зэрэгцэн ШУКО, түүхэн материализм, МАХН ба төрийн түүхээр мэргэшсэн, улс төрийн онолын бэлтгэлтэй тэр дотор гадаадад сурч ном үзсэн эрдэмтэн багш, судлаачид голлосон бүтээлч хүмүүс 1990 оны сүүлчээр улс төрийн шинжлэх ухааны тухай ярилцах, судалгаа хийх, их дээд сургуульд бие даасан хичээл болгон заах, мэргэжлийн анги салбар нээх талаар санаачилга гаргаж

эхэлсэн. Тэгэхдээ улс төрийн шинжлэх ухааныг манайд академийн чанартай онолын суурь судалгааны чиглэлээр биш, харин түүнийг их дээд сургуульд тусгай хичээл болгон заах, мэргэжил болгох чиглэл давамгайлсан байдлаар анх үүсгэжээ.

1990 оноос хойших үеийн улс төрийн хичээлийн агуулга нь үзэл суртлаас ангид байж, олон хувилбартай болж, агуулгын хувьд прагматик болох эхний алхмууд хийгдэж эхэлсэн. Тухайлбал, анх улс төр судлал хичээлийг заах багш нарыг бэлтгэх зорилгоор Польш, ЗХУ-д мэргэжил дээшлүүлж, МУИС-ийн ШУКО-гийн тэнхимийн суурин дээр Улс төр судлалын тэнхимийг байгуулах бэлтгэл ажил 1990 онд хийгдэж, тус тэнхимийн багш нар бусад их дээд сургуулийн ШУКО, ЗХУКН-ын түүхийн багш нар бүтэн нэг хичээлийн жил улс төр судлалын хичээлийн төлөвлөгөө, лекцийг боловсруулж, сургалт семинар хэлэлцүүлэг зохион байгуулжээ. 1992 онд одоогийн удирдлагын академийн төрийн удирдлагын тэнхимд богино хугацааны курс зохион байгуулагдаж, түүнд их дээд сургуульд улс төр судлал хичээлийг заах багш нар хамрагдаж байжээ [22]. Мөн онд МУИС мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж улс төр судлал, нийгмийн ухааны 22 багшийг хамруулж, сертификат олгож байв.

1992 онд “Улс төрийн шинжлэх ухааны үндэс” гэсэн анхны гарын авлага гарч, 1993 онд Улс төрийн боловсролын академи байгуулагдаж, 1994 онд тус академиас улс төр судлалын анхны тогтмол хэвлэл бүхий “Шинэ толь” сэтгүүлийг гаргаж эхэлсэн. 1996 онд мөн улс төрийн боловсролын академиас эрхэлж “Улс төр судлал” сурах бичгийн I дэвтэр /ред Б.Дэлгэрмаа/. 1996 онд А.Цанжидын “Улс төрийн шинжлэх ухаан” сурах бичиг хэвлэгджээ. Дээр дурдсан анхны ном, сурах бичиг, сэтгүүл гарсан явдал нь энэ хичээлийг үр дүнтэй заах, улс төрийн боловсролын талаар ард иргэдэд анхан шатны мэдэгдэхүйн ойлголт өгөх нөхцөл бололцоог бүрдүүлж өгсөн гэж үзэж болно.

Улс төр судлалын хичээлийг зааж эхэлсэн тэр үеэс МУИС-ийн “Улс төр судлалын тэнхим” /1991 онд МУИС-ийн захирлын тушаалаар хуучин ШУКО-гийн тэнхимийн суурин дээр улс төр судлалын тэнхим байгуулагдаж, тэнхимийн эрхлэгчээр НУФ-ын декан дэд доктор Ш.Содном хавсран ажиллахаар томилогджээ/-ээс боловсруулсан хичээлийн хөтөлбөр, ном сурах бичгийг бусад их дээд сургуулиуд сургалтандаа ашиглаж ирсэн. 1991-2000-аад он хүртэл төрийн өмчийн болон хувийн их дээд сургуулиудад улс төр судлалын хичээлийг өөр өөрсдийн онцлогт тохируулан цөөвөр цаг зааж байсан [23] бол өнөөдөр сургууль, багш бүр өөр өөрсдөө тухайн хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, агуулгыг тодорхойлох болжээ.

2000-аад оны үед их дээд сургуулиудад зааж байсан улс төр судлал хичээлийн хөтөлбөр нь улс төр шинжлэх ухаан болох нь, улс төрийн сэтгэлгээний эх үндэс, улс төрийн шинжлэх ухааны үндсэн парадигмууд, улс төрийн засаглал, улс төрийн засаглалын нийгмийн субъектууд, улс төрийн бодлогын социал үндэс, улс төрийн хошуучлал, нийгмийн улс төрийн систем, улс төрийн дэглэм, сонгуулийн систем, төр улс төрийн системийн үндсэн институт болох нь, улс төрийн нам, намын систем, улс төрийн соёл, нийгэмшилт, улс төрийн үйл байдал, улс төрийн үзэл суртал, улс төрийн шинэчлэл, улс төрийн мөргөлдөөн, геополитик зэрэг сэдвүүдийг багтаасан байв.

Түүнчлэн БСШУ-ны сайдын 2006 оны 12 сарын 29-ний 481 тоот тушаалаар “Монгол улсын дээд боловсролын стандартын үлгэрчилсэн загвар”-т өөрчлөлт оруулж, “Мэргэжлийн бус ангийн сургалтын агуулгын ерөнхий суурь хэсэгт зайлшгүй орох нийгэм, хүмүүнлэгийн ухааны хичээлүүдийг тодотгон тусгасан бөгөөд сургалтын агуулгад тусгах хүмүүнлэгийн ухааны болон нийгмийн ухааны хичээл тус бүр 2-оос цөөнгүй байна” хэмээн өөрчилсөн [24]. Мөн сонгон судлах нийгмийн ухааны хичээлүүдээс улс төр судлалын хичээлийг 2 багц цагаар тусгаж өгсөн байдаг. Энэ үеэс эхэлж улс төр судлалын хичээлийг их дээд сургуулиуд өөр өөрийн мэргэжлийн онцлогт тохируулан зааж байна.

## ДҮГНЭЛТ

Хүн төрөлхтөний түүхээс авч үзвэл анхны улс төрийн мэдлэг боловсролыг эртний Грек улсад олгож байжээ. Тэд 16-18 насныханд “Палестр” хэмээх боловсролын байгууллагаар дамжуулан биеийн тамир, улс төр, ёс суртахууны мэдлэг боловсрол олгодог байсан бол 18-20 насныханд “Эфеб” хэмээх боловсролын байгууллагаар дамжуулан цэрэг, улс төрийн мэдлэг, боловсрол олгодог байв. Харин манай улсад улс төрийн мэдлэг, боловсролыг албан ёсны хичээл сургалтаар олгож ирсэн түүхэн үе нь 1925 оноос эхэлсэн байдаг. Тиймээс улс төрийн сургалтыг социализмын үеийн үзэл сурталжсан байдлаас ардчилсан нийгмийн чөлөөт хэв шинж рүү шилжсэн гэж үзвэл түүнийг нэгдүгээрт, 1990 оноос өмнөх улс төр судлалын сургалт /социализмын үе/, хоёрдугаарт 1990 оноос хойших улс төр судлалын сургалт /ардчиллын үе/ гэж үечилж болох юм.

Социализмын үеийн улс төрийн боловсрол нь бүхэлдээ Марксист Ленинист философид үндэслэсэн бүх талын өв тэгш хүмүүжилтэй, социалист бие хүн төлөвшүүлэхэд чиглэж байсан бол ардчиллын үеийн улс төрийн боловсрол нь улс төрийн шинжлэх ухааны мэдлэг олгохын зэрэгцээ улс төрийн үйл явцад оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, үнэлэлт дүгнэлт өгөх, шийдвэр гаргах чадвартай, улс төрийн соёлтой, иргэний нийгмийн чиг баримжаатай бие хүнийг төлөвшүүлэхэд чиглэгдэх болсон.

### АШИГЛАСАН НОМ, ЗОХИОЛ

1. Вернадский Ж. Чингис хааны их Яса/засаг/-ын судалгаа түүний агуулга. Уб., 1992. 17 дахь тал
2. Дашням И. Монгол улсын төр, эрх зүйн түүх. 1 боть. Уб., 2005. 317 дахь тал
3. Пүрэвдорж Ч. Чингис хааны удирдахуй дагуулихуй. Уб., 2013. 144-145 дахь тал
4. Эх сурвалж. МАХН-ын баримтын төв архив.Ф-14,Д-1.ХН-2. 16 дахь тал
5. Дашиэвэг Б. Тойвгоо С. Түүхэнд мөнхөрсөн намын дээд сургууль. Уб., 2009. 22 дахь тал
6. Эх сурвалж. МАХН-ын баримтын төв архив.Ф-14,Д-1.ХН-23. 9 дэх тал
7. тал Эх сурвалж. МАХН-ын баримтын төв архив.Ф-14,Д-1.ХН-23. 26-48 дахь тал
8. Эх сурвалж. МАХН-ын баримтын төв архив.Ф-14,Д-1.ХН-23. 26 дахь тал
9. Цэнд-Аюуш Г. Улс төрийн ухамсар: түүхэн судалгаа. Уб., 2012. 115 дахь
10. Роозон Ж. МАХН-ын улс төрийн боловсролын систем: үүсэл хөгжил, цаашдын төлөв. Уб., 1984. 46 дахь тал
- 11] Ванчигсүрэн Д. Монголын сургалтын арга зүй, технологийн шинэчлэл. Монголын боловсрол судлаач эрдэмтдийн сонгомол өгүүдлийн түүвэр-XX зуун. Уб., 2002. 34 дэх тал
12. БСШУЯ. Монгол улсын боловсролын салбарын үүсэл, хөгжил 80 жилд. Уб., 2001. 12 дахь тал
13. Эх сурвалж. МУИС байнга хадгалах архивын данс. УТА Ф-1. Д-334. ХН-1. 51 дэх тал
14. Шагдар Ш. Монголын боловсролын түүхийн тойм. Уб., 2003. 86-87 дахь тал
15. Эх сурвалж. МУИС байнга хадгалах архивын данс. УТА Ф-334. Д-1. ХН-672. 54 дэх тал
16. Бэгз Н. Ванчигсүрэн Д /Ред/. XX зууны Монголын боловсрол судлал: туршлага ба сургаж. Уб., 2002. 8 дахь тал
17. Лувсандорж Ш. Галиймаа Н. Төр засгаас боловсрол, соёл, шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд. 1921-1990. Аугаа их түүхийн жимээр хамтдаа аялсан он жилүүд цуврал сэтгүүл. Уб., 2009. 21 дэх тал
18. Жамбал А. Монгол улсад улс төрийн шинжлэх ухаан үүсэн төлөвшиж байгаа нь. МУИС. Политологи сэтгүүл. №281. Уб., 2007. 38 дахь тал
19. Ганболд Ц. Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны сургалт судалгааны зарим асуудалд. МУИС. Политологи сэтгүүл. Уб., 2007. №281. 85 дахь тал
20. Эх сурвалж. Ардын Боловсролын Яамны байнга хадгалах архивын данс. УТА Ф-6. Д-5. ХН-49. 117 дахь тал
21. Эх сурвалж. МУИС байнга хадгалах архивын данс. УТА Ф-334. Д-2. ХН-383. 104 дэх тал
22. Ганболд Ц. ШУКО-ооо улс төр судлал хүртэл. Уб., 2012. 59 дэх тал
23. Ганболд Ц. Ред. Улс төрийн шинжлэх ухаан. Уб., 2001. 4 дэх тал
24. Долгор Б. Одмаа Д. Их дээд сургуулийн мэргэжлийн бус сургалтан дахь улс төр судлалын хичээлийн онцлог, шинэчлэлийн асуудалд. ШУТИС-НТС. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. Уб., 2013. 113 дахь тал